

## **“ЭДЦС” ТӨХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТОР Б.ГАНЧИМЭГИЙН 2024 ОНЫ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 он

ОРХОН АЙМАГ

2024 онд холбогдох хууль, тогтоомж, Эрчим хүчний сайдын 2023 оны А/271 дүгээр тушаалаар баталсан Эрчим хүчний салбарт мөрдөх дотоод аудитын аргачлал, салбарын дотоод аудитын загварын ажлын баримтыг удирдлага болгон “ЭДЦС” ТӨХК-ийн дотоод дүрэм, журмын хүрээнд дотоод аудитыг зохион байгуулж ажиллалаа.

### **Нэг. Удирдлага зохион байгуулалтын ажлын талаар:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 07, 08 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудиторт хүүхэд асрах эхийн чөлөө олгож ажлаас түр чөлөөлж, түүний оронд дотоод аудитораар түр томилогдон ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын 2024 оны А/128, 158 дугаартай тушаалын дагуу 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр өмнөх ажлыг хүлээлцүүлэн, 4 дүгээр сарын 19-ний өдөр Дотоод аудиторын ажлыг хүлээн авсан.

Дотоод аудиторын 2024 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр ТУЗ-ийн дарга баталсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийх удирдамжийг Аудитын хорооны даргаар тухай бүр батлуулж, дотоод аудит хийж, зөвлөмж, дүгнэлт өгч, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд аудит хийж ажиллалаа.

### **Хоёр. 2024 оны төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны талаар:**

Компанийн дүрэм журам, стандартын мөрдөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, НББ-ийн үнэн зөв хөтлөлт, бодит байдалд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган компанийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

Тус зорилтын хүрээнд дараах аудитыг хэрэгжүүлж үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгсөн байна.

2024 оны ажлын төлөвлөгөөний хамрах хугацаа 2024 оны 05 дугаар сараас 2025 оны 02 дугаар сар хүртэл.

| №      | Хамрах хүрээ           | Дотоод аудит хийх ажлын чиглэл  | Биелэлтийн тухай (товч)   |
|--------|------------------------|---|---|
| Аудит: |                        |   |   |
| 1      | ЗУХ,<br>СБЭЗХ,<br>ХААХ | Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн оруулсан эсэхэд аудит хийх.         | 2024.08.19-ний өдрийн батлагдсан удирдамжийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2024 оны эхний 7-н сарын байдлаар дотоод аудит хийв. 1 зөрчлийг илрүүлж, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв.<br>2025.01.21-ний өдрийн батлагдсан удирдамжийн дагуу 8-12 сарын мэдээллийг цахим хуудсанд мэдээлэл байршуулсан талаар зөвлөмж өгөв. 2 зөрчлийг илрүүлж, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв.   |
| 2      | ЗУХ,<br>СБЭЗХ          | Гүйцэтгэх захирлын 2024 оны тушаал шийдвэрийн хэрэгжилтэд түүврийн аргаар аудит хийх.   | 2024.06.17-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу Гүйцэтгэх захирлын 2024 оны эхний 5-н сарын байдлаар дотоод аудит хийв. 10 алдаа, зөрчлийг илрүүлж, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв.   |
| 3      | ХААХ                   | Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлд, аудит хийж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх.                                      | 2024.10.03-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны III улирлын байдлаар ХАА-нд түүврийн аргаар аудит хийв. Аудитаар 13 алдаа, зөрчлийг илрүүлж холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв.  |
| 4      | Холбогдох нэгжүүд      | 2023 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын газар болон бусад хяналт шалгалтаас өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт хийх. | 2023 онд хөндлөнгийн 3 хяналт шалгалт ирсэн. Үүнд:<br><u>ТӨБЗГ:</u> Компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж биелэлтийг ТӨБЗГ-т хүргүүлсэн. Мөн хэрэгжилтийг ТУЗ-ийн 2024 оны 10 дугаар сарын хуралд тайлагнасан.<br><u>ЭХЯ:</u> Компанийн 2022 он, 2023 оны III улирлын байдлаар санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, ИЗ, ТЗБАХ, ХО, санхүүгийн дотоод хяналтын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд аудит хийж, биелэлтийг ЭХЯ-д хүргүүлсэн.<br><u>Төрийн аудит:</u> Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаас өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд аудит хийж биелэлтийг ЭХЯ-д хүргүүлсэн. Мөн хэрэгжилтийг ТУЗ-ийн 2024 оны 10 дугаар сарын хуралд танилцуулж, тайлагнасан.<br>Дээрх хөндлөнгийн хяналт шалгалтаас өгсөн хэрэгжилтээс бүрэн хангагдаагүй үүрэг даалгавар, зөвлөмжийг нэгтгэн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг Гүйцэтгэх захиралд танилцуулж ажиллав. |
| 5      | СБЭЗХ                  | 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх.   | Төлөвлөгөөний дагуу холбогдох удирдамжийг боловсруулан аудитын хороонд танилцуулсан. Аудитыг 2025.02.24-ны өдрөөс 2025 оны 1-р дүгээр улирал хүртэл хийж дуусгахаар төлөвлөж байна.   |

|                             |       |   |   |
|-----------------------------|-------|---|---|
| 6                           | СБЭЗХ | Компанийн ажилтнуудын ажлын цаг ашиглалт, цаг бүртгэлийн үйл ажиллагаанд аудит хийх.  | Энэ ажил хийгдээгүй, хугацааны хувьд амжсангүй. 2025 оны хийх ажлын төлөвлөгөөнд шилжүүлж аудит хийхээр тусгалаа.   |
| Сургалт хөгжүүлэлт ба бусад |       |   |   |
| 1                           |       | ISO27001:2021 мэдээллийн технологи, Аюулгүй байдлын арга техник, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх төслийн багт ажиллаж, тус стандартыг нэвтрүүлэхдээ холбоотой өөрийн ажлын байрны мэдээллийн аюулгүй байдлын мэдээллийн урсгал, үр нөлөөг тодорхойлох | ISO27001:2021 мэдээллийн технологи, Аюулгүй байдлын арга техник, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог компанид нэвтрүүлэх төслийн багт ажиллаж байна. Компанийн ИТА-аас эрсдэлийг бичүүлж түүнийг аргачлалын дагуу боловсруулав, мөн стандартын шаардлагад туссан эрсдэлүүдээс компанид хамааралтай эрсдэлийг тодорхойлж тус стандартын дагуу түүнд боловсруулт хийв. МАБ-ын эрсдэлийг тодорхойлж үнэлж, дүгнэх багийг ахлан ажилласан. |
| 2                           |       | Монголын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс зохион байгуулдаг татварын мэргэшсэн зөвлөхийн сорил болон эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтад хамрагдах, сорил шалгалт өгөх.  | Монголын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс зохион байгуулдаг татварын мэргэшсэн зөвлөхийн сорил шалгалтад бэлтгэх сургалтад хамрагдсан, сорил шалгалт өгч тэнцсэн.  |
| 3                           |       | Дээд газар, мэргэжлийн байгууллага болон компаниас зохион байгуулж байгаа сургалт, арга хэмжээнд оролцох.   | Дээд газар болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад тухай бүрд хамрагдаж байна.  |
| 4                           |       | Эрчим хүчний салбарын спортын их наадамд сагсан бөмбөг, волейболын төрөлд оролцох.  | Хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг Эрчим хүчний салбарын спортын их наадамд 2024 онд зохион байгуулагдсан. Тус тэмцээнд сагсан бөмбөг, волейбол гэсэн төрлөөр оролцсон.  |
| 5                           |       | Шилэн дансны тухай журмыг шинэчлэн боловсруулах, Гүйцэтгэх захиралд танилцуулж батлуулах.   | Компанийн “Шилэн данс, мэдээллийн самбарын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай журам”-ын төслийг боловсруулж, Гүйцэтгэх захиралд танилцуулж хүлээлгэн өгсөн.   |
| 6                           |       | Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитын ажиллах журам боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.  | ТУЗ-ийн дэргэдэх “Дотоод аудиторын үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, аудитын хороонд танилцуулж ТУЗ-ийн 2024.12.30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх материалыг бэлтгэн танилцуулж, батлуулсан.   |
| 7                           |       | Дотоод аудитын ажлын баримтууд, аудитын зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний талаарх баримтыг бүрдүүлэн архивын нэгж болгох.  | Дотоод аудитын ажлын баримтууд, аудитын зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний талаарх баримт, тайланд хугацаанд хийсэн ажлын тайлан бусад баримт бичгүүдийг бүрдүүлэн архивын нэгж болгон хугацаанд нь буюу 2025.03.31-ний дотор компанийн архивд хүлээлгэн өгнө.  |
| 8                           |       | Компанийн нэгж хэсэгт хийгдсэн эрсдэлийн үнэлгээтэй танилцах, эрсдэлийн үнэлгээ хийх ажилд идэвх санаачилгатай оролцох  | 2024 оны байдлаар компанийн хэмжээнд нэгдсэн эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна. ХАБ-ын эрсдэлийг тодорхойлж үнэлсэнтэй танилцсан. ISO27001:2021 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог компанид нэвтрүүлэх төслийн багт ажиллахдаа МАБ-ын эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах ажлыг хэсгийг ахлаж ажиллаж байна. Тус ажил 2025 оны нэг дүгээр улиралд хугацаанд хүлээлгэн өгч дуусгана.     |

|   |  |  |
|---|--|--|
| 9 | 2024 оны жилийн ажлын тайлангаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах. 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг батлуулах. | Дотоод аудитын 2024 оны ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулсан. 2024 оны жилийн ажлын тайлангаа бэлтгэн аудитын хороонд танилцуулсан. ТУЗ-д тайлагнахаар бэлдэж байна. 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж аудитын хороонд танилцуулсан, ТУЗ-д танилцуулж батлуулахаар материалыг бэлдэж байна. |
|---|--|--|

(Батлагдсан удирдамжийн дагуу дотоод аудит хийсэн тайлангуудыг хавсаргав)

**Гурав. Бусад хийгдсэн ажлын талаар:**

- ❖ 2024 онд хөндлөнгийн хяналт шалгалтаар ирсэн багт дотоод аудиторын ажлыг танилцуулж, шаардлагатай материалуудыг өгч ажиллалаа.
- ❖ ЭХЯ болон “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК хамтран 2024 оны 09 дүгээр сард 2 өдрийн хугацаатай зохион байгуулсан Эрчим хүчний салбарын дотоод аудиторуудын зөвлөгөөнд оролцсон.
- ❖ Дээрх зөвлөгөөнөөс “ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журамд нэмэлт өөрчлөлт оруулах” гэсэн зөвлөмжийг компанийн ТУЗ-д өгсөн. ЭХЯ-аас тус зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллахыг албан бичгээр ирүүлсэн. Үүний хүрээнд Аудитын хорооны үйл ажиллагааны журамд дотоод аудитортой холбоотой өөрчлөлтийг оруулах саналаа өгч, аудитын хороонд танилцуулсан. Тус асуудлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын хурлаар хэлэлцэн баталж, ЭХЯ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн.
- ❖ Дотоод аудиторын ажлын байрны тодорхойлолтыг холбогдох дүрэм журмын дагуу боловсруулж, Аудитын хороогоор хянуулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.
- ❖ Мөн салбарын дотоод аудиторуудаас туршлага судалж, Дотоод аудиторын сарын болон жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсний шалгуур үзүүлэлтийг боловсруулж Аудитын хороонд танилцуулан хянуулж, ТУЗ-ийн хуралд танилцуулж албажуулав.
- ❖ Дээд газраас ирүүлсэн хариутай бичгийг хугацаанд хүргүүлсэн.
- ❖ ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар 2020 оноос 2024 оны 11 сарын 15 хүртэл ажилласан. Тайлант хугацаанд батлагдсан хуваарийн дагуу хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох мэдээллүүдийг бэлтгэн гишүүд болон ЭХЯ-д хүргүүлж, нийт 15 удаагийн хурлыг цахим болон танхимаар зохион байгуулж 15 хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл бичиж, хэлэлцэх асуудалтай холбоотой 9 тэмдэглэл, 22 тогтоолын төслийг боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажилласан. Мөн 2024 оны ХЭХ-ын бэлтгэл ажлыг хангаж, хурлаар 6 асуудлыг хэлэлцэж, 6 тогтоол батлагдсан.

ТУЗ-ийн нарийн бичгийн ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр комисст хүлээлгэн өгөв.

**Дөрөв. Цаашид тавих зорилт:**

- ❖ 2025 онд дотоод аудитаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг бүрэн хангуулахад анхаарч ажиллана.
- ❖ Мэргэжлийн ур чадвартай байх үүднээс мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлнэ.
- ❖ Дотоод аудиторын дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батлуулах.

**Тав. Санал, хүсэлт:**

- ❖ Цалингийн түвшинг нэмэгдүүлэх саналтай байна. (Хүсэлтийг хавсралтаар хүргүүлэв)

**ТАЙЛАН БИЧСЭН:**

АУДИТОР:



Б.ГАНЧИМЭГ